

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20~~25~~ оны 03 сарын 17 -ны өдөр

№ 11

Улаанбаатар хот

Арилжааны банкинд зээлийн шугамын эрх нээлгэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.29 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Банк бус санхүүгийн байгууллагын харилцагчдад зээл олгох, зээлийн эрэлтийг хэвийн хадгалах, бизнес төлөвлөгөөний хүрээнд “Сэндли ББСБ” ХК-ийн нэр дээр Капитрон банканд дараах нөхцөлөөр зээлийн шугамын эрх нээлгэхээр тогтсугай.

Зээлийн эрхийн хэмжээ: 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөг
Зээлийн эрхийн хугацаа: 24 /хорин дөрвөн/ сар
Зээлийн хүүгийн хэмжээ: сарын 1.9 /нэг аравны ес/-н хувь,
жилийн 22.8 /хорин хоёр аравны найм/-н хувь

2. Энэхүү тогтоолын 1-д заасан “Сэндли ББСБ” ХК-ийн зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор 10,000,000,000 /арван тэрбум/ төгрөгийн дүн бүхий хэрэглээний, үл хөдлөх хөрөнгө болон автомашин барьцаалсан хэвийн зээлийн багцийг барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.

3. Банктай зээлийн болон барьцааны гэрээ байгуулах, гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/, Үйл ажиллагаа хариуцсан захирал /Б.Ичинхорлоо/ нарт олгосугай.

4. Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулж ажиллахыг Эрсдэл хяналт, шалгалт хариуцсан захирал /Д.Баярбат/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ

